



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 287

Улаанбаатар хот

Г Санхүүгийн зохицуулах хорооны Г  
2007 оны 156 дугаар тогтоолын хавсралтад  
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 156 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ” гэснийг “Үнэт цаасны зах зээлд оролцогч хуулийн этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ” гэж өөрчилсүгэй.

2. Хавсралтад энэхүү нэмэлт, өөрчлөлтийг оруулж биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН